

УЛАМЖЛАЛТ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ
СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦТАЙ УЯЛДУУЛАХ НЬ

Ч.Батчимэг

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн,
гадаад хэлний тэнхимийн ахлах багш цагдаагийн ахмад

Резюме: Боловсрол судлалын тулгамдсан асуудалд бие хүний боловсролыг хөгжил, төлөвшил болон зан үйлийнх нь ахиц өөрчлөлттэй холбон авч үзэх парадигм хандлагыг судалж үзнэ.

Investigate the paradigm approach to individual education in connection with the improvement of his development, forming and behavior in educational research, will be investigated.

Изучение парадигматического подхода образования личности в актуальных проблемах образования в увязке с изменением его развития, формирования и поведения.

Хураангуй:

Боловсрол судлалын үндсэн асуудалд бие хүний боловсрол, бие хүний хөгжил, төлөвшил болон зан үйлийнх нь ахиц өөрчлөлтийг боловсролын агуулга, боловсролын олон талт үйл явцтай холбон парадигмыг оруулсан болно.

Түлхүүр үг хэллэг: Боловсрол судлал, бие хүний боловсролын хөгжил төлөвшил, парадигм хандлага, боловсролын олон талт үйл явц, зан үйлийн шүтэлцээ

Боловсрол судлал нь “Эдукология” гэсэн орос үг бөгөөд үүний эхний үндэс “Эдук” нь Education (боловсрол) гэсэн англи үг юм. “Логия” логос нь сургааль судлал гэсэн грек гаралтай үг юм. Бие хүний боловсролыг хөгжил, төлөвшил, зан үйлийнх нь ахиц өөрчлөлттэй холбон байгалийн, нийгэм-хүмүүнлэгийн болон сэтгэцийн шинжлэх ухаануудын, мөн амьдралын боловсролын асуудлыг шүтэлцээнд судалдаг нийлмэл шинжлэх ухаан юм.

Боловсрол судлалын үндсэн болон тулгамдсан асуудлыг бие хүний боловсрол, түүний олон талт үйл явц, хүмүүжил, хөгжил, төлөвлийн боловсрол; бие хүний физиологи-сэтгэл зүйн хөгжлийн боловсрол гэсэн хэсгүүдээр авч үзэж болох бөгөөд эдгээр нь өөр хоорондоо шүтэлцээт агуулгатай боловсролын олон талт хандлага юм гэж үзээд боловсролыг хүн төрлөхтний олон мянган жилийн турш хуримтлуулсан бүх төрлийн шинжлэх ухааны мэдлэгийн өв сан; амьдралаас, туршлагаас болон орчноос эзэмшсэн мэдлэг чадварын цогцос юм гэж тодорхойлсон¹ нь аливаа хүний хөгжил төлөвшил, зан үйлийг амьдралынх нь туршид судлах шаардлагатайг өгүүлсэн байна.

Хүн, түүний боловсролын талаарх парадигм үзэл баримтлалаас үүдэн бие хүн гэдэг ухагдахууныг орчны юмс үзэгдлээс хүн бүр өөрийнхөө хэрэгцээ болгон хувиргаж ашиглах үйл явцын үр дүн; байгаль орчинтой, мэдээлэлтэй, шинжлэх ухаан, үйлдвэрлэл болон олон талт үйл явцад уян хатан олон хувилбараар харилцаж ажиллах арга барил, ашигтай, үнэ цэнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явцын багтаамж, хэм хэмжээ; хүн өөрийгөө шинжин таньж зөв удмрдан, юмс үзэгдэл болон орчинтой дасан зохицох боломж чадамжтай тус тус холбон авч үзвэл бие хүний боловсролын асуудал нь хүний хөгжил, төлөвшил, зан үйлтэй холбогдож тодорхой болно.

Хүүхдийн бие бялдар, оюуныг хагжүүлэх үйлдлийг бага сургуулийн насанд эцэг эхчүүд гэр орны энгийн ажилд оролцуулж, мал маллах арга ухаанд суралцуулж хүнтэй зөв харилцах сайхан хувцаслаж биеэ сайхан авч явахад чиглүүлж байсан нь уламжлалт арга барил залуучуудыг нийгэм-сэтгэл зүйн болон бие бялдарын өв тэгш хөгжилтэй болгож төлөвшүүлэхийн стандарт бус үнэлгээ бүхий нэн чухал үйл ажиллагаа байжээ.

Өнөө үед суралцагчдын мэдлэг, чадвар төлөвшлийг үсгэн үнэлгээгээр яаж суралцаагийг нь илрүүлэх боломжгүй юм. Суралцагчдын яаж суралцдаг онцлогийг судлан илрүүлж түүнд нь тулгуурлан нийгэмшил, бие оюуны болон сэтгэцийн хөгжлийн явц, үр дүнгийн ахиц, өөрчлөлтийг судалж, дүн шинжилгээ хийх стандарт бус үнэлгээний арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх нь бүх шатны сургуулийн тулгамдсан асуудлын нэг юм.

Суралцагчдын нийгэмшил, бие, оюун сэтгэцийн хөгжил нь зөвхөн бүх шатны сургуулиар төдийгүй амьдралынхаа явцад сонирхол, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан уян хатан, олон хувилбар бүхий нэгдмэл үйл явцаар дамжин сурах, суралцах болон сургах үйл үйлийн нэгдлээс хамаардаг нарын төвөгтэй үйл явц юм. Энэ үйл явцыг зарим их дээд сургуулиудын сэтгэл судлалын тэнхим суралцагчдын ой тогтоолт анхаарлын болон сэтгэхүйн чанар талаас нь судалж байгаа.

Суралцагчдын яаж суралцдагийг судлан илрүүлсэнтэй тулгуурлан хөгжил төлөвшлийнх нь ахиц өөрчлөлтийг судлахад сэтгэл судлалын конструктив, когнитив болон бусад онолыг хэрэглэж байгаа.

Бие хүний боловсролыг социал хөгжил төлөвшлийнх нь үндсэн шинж чанар болох гоо зүй, ёс суртахуун, сурч хөдөлмөрлөх арга ухаан юмс үзэгдэл амьдралыг нэгдмэл ертөнц болгон авч үзэх хандлага гэсэн элментүүдээр, сэтгэц физиологийн шинж чанарыг мэдрэхүйн эрхтүүдийг хүлээн авах чадвар, боловсруулалт хийх чадвар, авъяас чадвар, нервийн систем гэсэн элментүүдээр авч үзнэ. Бие хүний боловсролыг хөгжил төлөвшилтийнх нь ахиц өөрчлөлттэй холбон авч үзэх нь боловсрол судлалыг шинжлэх ухаан болгож авч үзэх чухал баримтлал юм.

Ингэхлээр боловсрол судлалын тулгамдсан асуудалд бие хүний амьдрах ухааныг боловсролын үйл явцын хүрэн дэх хүмүүжил, хөгжил, төлөвшил; бие хүний хүмүүжил, хөгжил төлөвшлийн боловсролтой холбоо бүхий хүн бүрийн байгалийн нийгэм хүмүүнлэгийн мэдлэг танин мэдэхүйн үйл явцын боловсрол, бие хүний боловсрол болон хүмүүжил, хөгжил төлөвшил, мэдлэг, сургалтын танин мэдэхүйн үйл явц дахь физиологи-сэтгэл судлалын боловсролын агуулга, арга зүйг хамруулан авч үзэж болох юм.

Ийм учраас энэ асуудал бол бие хүний шууд болон сэтгэж мэдрэн таних үйл, дээд мэдрэлийн үйл ажиллагааны физиологи-сэтгэл судлалын боловсролтой холбоотой юм. Бие хүний хүмүүжил хөгжил төлөвшлийн боловсролыг сургалтын олон хувилбар бүхий үйл явцын болон амьдралын үр дүн болох боловсролыг олон талт үйл явцуудын уялдаа холбоо нэгдэлт “Боловсрол судлал шинжлэх ухааны хувьд” “Бие хүний хөгжлийн диаграмаар авч үзэн судалсан нь судалгааны гол үндэс болж байгаа юм.”

Бие хүний хөгжлийн диаграмаас авч үзвэл аливаа юмс үзэгдэл, ухагдахууныг хүн амьдралынхаа явцад олон талаас нь ажиглаж тэдгээрт зайлшгүй холбоотой асуудлыг судлан дүн шинжилгээ хийж хэрхэн үр ашигтай шийдвэрлэх чигэлэлээр өөрийгөө удирдан дасан зохицон ажиллахад боловсролын ололн талт үйл явцын мэдлэг, туршлага шаардлагатай юм.

Энд л бие хүний социал хөгжил төлөвшлийн боловсрол чухал ач холбогдолтой юм. Энэ боловсрол нь сурч хөдөлмөрлөх арга барил юмс үзэгдлийг нэгдмэл ертөнц болгон авч үзэх ухаан, юмс үзэгдэлд хандах гоозүйн болон ёс суртахууны төлөвшлийн үр дүнтэй холбоотой.

Бие хүн амьдралынхаа явцад мэдлэгийн түвшин болон туршлагадаа тулгуурлан сурч хөдөлмөрлөснийхөө үр дүнг тоо, чанар, үр ашиг, өгөөжөөр хэмжих арга бариолтай холбох нь амьдрах ухааны нэн чухал боловсрол юм. Бие хүний насан туршийн нийгэмшил (Социал төлөвшил) болон туршлага нь юмс үзэгдлийг хэрхэн ухамсарлаж, яаж сэтгэн бодох (оюун ухааны хөгжил) үүднээс зөв хүлээн авч боловсруулах, үр дүнгий нь тооцон дүн шинжилгээ хийж цаашдын хандлагаа урьдчилан зөв харах сэтгэл физиологийн хөгжил төлөвшлийн боловсролтой холбоотой юм.

Ингэхлээр боловсрол судлалын тулгамдсан асуудал нь тус бүрдээ өргөн утга агуулгатай хэрнээ өөр хоорондоо нягт органик холбоотой бие хүний сурч хөдөлмөрлөн хөгжих үйл ажиллагааны боловсрол (“Сурган хүмүүжүүлэх зүйн боловсрол”), амьдралынхаа явцад аливаа юмс үзэгдэлтэй хэрхэн харьцахтай холбоотой оюун ухааныг хөгжүүлэх боловсрол буюу (сэтгэл судлалын боловсрол) болон сурч хөдөлмөрлөн амьдрах явцад юмс үзэгдэл, ухагдахууныг уураг тархиндаа зөв удирдлагаар хүлээн авч боловсруулан үр дүнд нь судалгаа хийж амьдрал ажил үйлийнхээ цаашдын чиг хандлагыг урьдчилан харах мэдлэг чадвартай байхуйц бие хүний сэтгэц физиологийн хөгжлийн боловсрол гэх мэт парадигм хандлагийг авч үзэх шаардлагатай юм.

Бие хүний хөгжлийн диаграммд үзүүлсэн түүний хөгжлийн бүтцийн элементүүд нь өөр хоорондоо зайлшгүй холбоотойгоос гадна нэг элементээр бусдыг хамруулж судалж болох юм. Энэ нь бие хүний боловсролын асуудлыг зөвхөн бүх шатны сургуулийн сургалтын явцад төдийгүй сургалтын гадна орчинд авч үзэх боломж бүрдүүлж байгаа юм. Тухайлбал: Ямар нэгэн юмс үзэгдэл болон ажил үйлийг хийж гүйцэтгэхийн тулд өмнөх мэдлэг, туршлагадаа тулгуурлан

өнгө, хэлбэр, дүрс хөдөлгөөн гэх мэт гадаад шинжээр нь дотоод бүтэц бүрэлдэхүүн бүхий агуулгаар нь авч үзэх нь тэр юмсын хувьд гоо зүйн хүртэхүй юм.

Энэ ойлголт нь хүн бүрт харилцан адилгүй байдаг бөгөөд хүн бүрийн ажиглах болон сэтгэн бодох үйл ажиллагааны хөгжил, төлөвшил өөр өөр байдагтай холбоотой юм. Ийм учраас хүртэн хүлээж авч боловсруулсан зүйлийнхээ үр дүнгээр тухайн ажил үйлийг хийж гүйцэтгэж байгаа хүмүүс болон бүлэг хамт олны үйл ажиллагааг үнэлж байр эзлүүлэх нь бас л ялгаатай буюу алдаа дутагдалтай байдаг.

Энэ бүхэн нь уг үйл ажиллагааны хувьд гоо зүйн таашаал юм. Дээр өгүүлсэн тухайн ажил үйлийн ололт дутагдлыг өөрийнхөө боломжит бүхийл харилцаа, зөв хариулт бүхий шийдвэр гаргаж байгаа арга быарил, эдгээртэй холбоотой өөрийгөө удирдах ухаан бодол зэрэг чадамжууд нь гоо зүйн мэдрэмж юм.

Ийнхүү уг ажлыг гоо зүйн хүртэхүй гоо зүйн таашаал болон гоо зүйн мэдрэмж дээр тулгуурлаж аль болох бүрэн зөв гүйцэтгэх боломжтой болно энэ нь гоо зүйн ажиллагаа юм. Ингэж ажилласнаар уш ажил үйлийг цаашид уян хатан хэрнээ аль болох ашигтай олон хувилбараар хийж гүйцэтгэж болохоо урьдчилан харах боломж бүрдэнэ. Энэ нь тэр ажлын хувьд гоо зүйн хандлага юм. Энэ мэтээр ажил үйл, амьдралаа өгүүлсэн таван үйл ажиллагааны нэгдэлд авч үзэж хэрэгжүүлж байвал гоо зүйн төлөвшил болно.

Энэ мэтчилэнгээр тухайн ажил үйлдээ олон арга барилаар харилцаж ажиллах явцад чанар, үр ашиг, өгөөжийг тооцох сэдэл тэмүүлэл өрнөж, тухайн ажилдаа ул сууртай хандаж олон түмний дунд нэр хүндтэй болох мэтээр ёс суртахууны хувьд төлөвшиж чадсанаараа хувь хүний хийж гүйцэтгэх ажилдаа итгэл үнэмшилтэй хандахаас гадна тэр ажилд хамаатай бүхийл хүчин зүйлүүдийг тухайн бие хүн зөвхөн өөртэйгөө төдийгүй бусад хүмүүс байгаль орчинтой холбон авч үзэх боломжтой болж боловсролын олон талт хандлагыг хөгжилт төлөвшилт, зан үйлтэйгээ холбон хэрэгжүүлэх болно.

Энэ мэтчилэн сэтгэн бодож ажиллахад сурч хөдөлмөрлөх арга барил, ажил амьдралын туршлага, ур чадвар бүхий нэгдмэл ертөнц бие хүнд төлөвшинө.

Ингэхлээр хүний боловсролын асуудал нарийн төвөгтэй бөгөөд хүн бүрийн амьдралаасаа олж авч буй боловсролыг бүр нарийн тооцох шаардлагатай байгаа юм.

Гэтэл зөвхөн бүх шатны сургуулиар олж авч буй боловсрол нь тухайн хүний боловсролын зөвхөн гуравны нэг хувийг эзэлж байдгийг хүүхэд эхээс төрсөн үеэс арван нас хүртэлх эгшинд зөв хөдөлгөөн хийх, зөв ярих, хүмүүстэй зөв харилцах, эцэг эх болон хамад хүмүүсийг, ер нь аливаа хүнийг хүндэлж сурах гэх мэт хүмүүжилд суурилсан сургалтын боловсрол олж авдаг. ЕБС-д суралцах хугцаандаа сурч хүмүүжихийн боловсролтой болдог 26-35 нас орчимд хөгжин төлөвших явцаа суралцахын боловсрол олж авна. Цаашдаа хөгжин төлөвшиж туршлагжсан боловсролтой болдог.

Суралцагч бие хүн нь төрөлх хэл, төрсөн газар орон, үндэстэн ястны онцлог, хүн амзүйн бодлого судлал (эмэгтэй, эрэгтэй) ажил мэргэжил гэсэн таван холбоо хамаарал болох социал тогтолцоонд сурч боловсорч, хөгжиж төлөвшиж байдаг. Энэ тогтолцоонд шаардлага, нөөц, зохицох биеэ дайчлах чадвар олж авна.

Боловсрол бол шинжлэх ухаанд судлагдаж болох үйл ажиллагааны нийлбэр цогц буюу объектив бодит чанаруудыг тодорхойлдог социал үйл явц юм. Хүн байгаль, нийгэм болон сэтгэхүйн шижлэх ухаантай, өөртэйгээ буюу хүмүүстэй, янз бүрийн орчинтой байнгын ухамсартай харьцаанд байдгаараа хөгждөг билээ. Хэдий чинээ зөв харьцана тэр хэмжээгээрээ юмс үзэгдэлтэй дасан кохицож амьдардаг. Дасан зохицох нь хүн болгонд адилгүй. Бие эрхтнүүдийн юмс үзэгдлийг хүлээн авах чадвар өөр өөр байдаг.

Хүн мэдлэг туршлагаа ашигласан юмс үзэгдэл болон мэдээдэдүүээс аль хэр хүлээн авч боловсруулалт хийснээр тэдгээрийн дүр зураг тархинд янз бүрээр хадгалагддаг. Хүн бүрийн төрөлх байгууламжийн онцлог юмс үзэгдлийг хүлээн авах боловсруулах чадвар, орчин тойронд хандах сонирхол, хэрэгцээ амьдралын шаардлага гэх мэтийн хүчин зүйлүүд нь хүний шинжлэх ухаанаас, амьдралын орчиноос олж авсан боловсролыг хөгжил төлөвшилтэйн холбон судлахын чухал хөшүүрэг болж байдаг.

Дүгнэлт

Боловсрол судлалын тулгамдсан асуудлыг дээр өгүүлсэн парадигм хандлагаар авч үзэхээс гадна монголын уламжлалт арга ухаантай холбон авч үзэх нь уг асуудалд ул суурьтай хандах тулгуур үндэс юм.

Их сэтгэгч Данзанравжаагийн

“Анхан даа болгоомжлон бод

Дунд нь шинжлэн оно

Эцэст нь зохицуулан тавь” энэ 3 нийлвээс төгөлдөр болно гэж айлдсан сургааль нь бие, сэтгэл, ухаанынэшдмэл боловсролд нилээд нарын цаг хугацаа шаардахыг өгүүлжээ.

Эрдэмтэн Шагжмуни Нагаржуна:

Бэр х зовлонг тэсэн чадвал хатуужил мөн

Бэрх үйлийг бүтээж чадвал эрхэм мөн

Бэрх утгыг мэдэж чадвал хурц мөн

Бэрх хорлолыг хариулж чадвал хүчит мөн гэж сургамжилсан нь боловсрол бол хүн бүрээс бэрхшээлийг даван туулах хүч чадал бүхий хатуужил; бэрх үйлийг эзэгнэх чадамж; аливаа зүйлийн ил далд утгыг илрүүлэн холбох эзэмшил хэрэглэх хурц ухаан шаардлагыг илтгэж байгаа болно.